



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/2013

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 2.4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нарийнтээл сумын “Тээлийн улаан” нутгийн шилмэл хэвшлийн ямааны удам зүйн үнэлгээ, генетик тогтцыг тодорхойлох, гематологи биохими, сүүний гарц, чанарын судалгааг хийхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Судалгааны ажилд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3. Судалгааг батлагдсан арга зүйн дагуу технологит хугацаанд явуулах ажлыг чанартай зохион байгуулж, үр дүнг нэгтгэн 2023 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0457

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр
сарын 17-ны өдрийн 17/2023 дугаар
захирамжийн хавсралт

НАРИЙНТЭЭЛ СУМЫН “ТЭЭЛИЙН УЛААН” ЯМААНЫ СУДАЛГААНЫ
АЖИЛ ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Төрөл	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт зардал
1.	Генетик тогтоцыг тодорхойлох	100	25,000	2,500,000
2.	Гематологи биохимийн судалгаа	60	45,000	2,700,000
3.	Сүүний гарц, чанарын судалгаа	738	6,500	4,800,000
Нийт				10,000,000

-оОо-